



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

**2023.IV**  
**улирал**

**2024 оны 3 дугаар сар**

---

**МОНГОЛБАНК**

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.


# 1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

**Ерөнхий индекс:** Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2023 оны IV улиралд тэлэлтийн мужид **58.6%**-тай гарлаа. Энэ нь өмнөх улирлаас 3.2 нэгж хувиар буюу бага зэргийн өсч, сүүлийн 5 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа. Өмнөх улирлын үзүүлэлтээс өсөхөд ажил эрхлэлтийн үзүүлэлт өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ /Зураг 1-2/.


**Нийлмэл индекс:** Нийлмэл индексүүдийн хувьд үйлдвэрлэлийн индекс сүүлийн 7, бараа материалын нөөцийн индекс сүүлийн 4, шинэ захиалга сүүлийн 3 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол өмнөх улиралд агшилтын мужид гараад байсан ажил эрхлэлтийн үзүүлэлт энэ удаад өмнөх улирлаас 13.3 нэгж хувиар өсч, тэлэлтийн мужид шилжлээ. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт агших мужид хэвээр байгаа хэдий ч өмнөх улирлаас төдийлөн өөрчлөлтгүй, өмнөх үр дүнгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр утгаа авсан хэвээр байна /Зураг 2/.

**Салбарын индекс:** Энэ улиралд барилгын салбараас бусад салбарын үзүүлэлт тэлэх мужид гарлаа. Аж үйлдвэр болон үйлчилгээний салбар тус бүр 7 улирал, дотоод худалдааны салбар сүүлийн 4 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол барилгын салбарын индекс агших мужид хэвээр гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлчилгээний салбарын индекс 5.9, аж үйлдвэрийн салбарын индекс 3.9 нэгж хувиар нэмэгдсэн бол барилгын салбарын индекс 4.8, дотоод худалдааны салбарын индекс 1.5 нэгж хувиар тус тус буурлаа /Зураг 3/.


**Зураг 1. Ерөнхий индекс**



**Зураг 2. Нийлмэл индекс**




**Зураг 3. Ерөнхий индекс, салбараар**



Үйлдвэрлэлийн индексийн утгыг бодит ДНБ-ий жилийн өөрчлөлттэй харьцуулан харахад үйлдвэрлэлийн индексийн утга 50%-аас их гарсан дийлэнх үеүүдэд бодит ДНБ өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна. 2023 оны IV улирлын үйлдвэрлэлийн индексийн утга өмнөх улирлаас бага зэргийн өсч 62.2%-тай гарсан нь тус улиралд эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас нэмэгдсэн үзүүлэлттэй нийцтэй байна /Зураг 4/.

**Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс**




## 2. Салбарын үзүүлэлтүүд

**Аж үйлдвэр:** Тайлант улирлын салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утгаас бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарлаа. Өмнөх улиралтай харьцуулахад ажил эрхлэлтийн үзүүлэлт 14.5, үйлдвэрлэл 6.5 нэгж хувиар тус тус өссөн бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон бараа материалын нөөцийн үзүүлэлтүүд бага зэрэг буурсан төлөвтэй байна /Зураг 5/.

Нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд худалдан авалтын тоо хэмжээ өмнөх улирлаас 11.9, бэлэн бүтээгдэхүүн 10.0 нэгж хувиар тус тус буурсан нь салбарын гол өөрчлөлт болж байна. Мөн түүхий эд, материалын үнэ 5.8 нэгж хувиар буурсан дүр зурагтай байгаа бол дуусаагүй үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний үнийн үзүүлэлтүүдэд төдийлөн өөрчлөлт ажиглагдсангүй. Харин бизнесийн үйл ажиллагааны төлөв тэлэлтийн мужид сүүлийн 5 улиралд хэвээр хадгалагдаж, өмнөх улирлаас 29.7 нэгж хувиар өсч, тус салбарын ирэх улирлын хүлээлт харьцангуй сайжирлаа /Хүснэгт 1/.

**Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**



**Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд**


Үзүүлэлт	2023.II	2023.III	2023.IV
Дуусаагүй үйлдвэрлэл	63.8↑	61.0↓	61.1
Бэлэн бүтээгдэхүүн	59.7↓	64.1↑	54.1↓
Бүтээгдэхүүний үнэ	63.4↓	68.6↑	69.1
Худалдан авалтын тоо хэмжээ	52.5↓	70.8↑	58.9↓
Түүхий эд, материалын үнэ	83.0↓	87.4↑	81.6↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	52.9↓	51.9↓	81.6↑

**Барилга:** Тус салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд энэ улиралд бараа, материалын нөөцийн үзүүлэлт агшилтын мужаас тэлэлтийн мужид шилжиж муудсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт сайжирсан дүр зурагтай байна. Мөн шинэ захиалга болон үйлдвэрлэлийн үзүүлэлт харгалзан 19.1, 6.1 нэгж хувиар тус бүр буурсан бол ажил эрхлэлтийн үзүүлэлт 10.3 нэгж хувиар өслөө /Зураг 6/.

Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд орон сууцны зах зээлийн идэвхжил өмнөх улирлаас 37.2 нэгж хувиар буурч, 2021 оноос хойш хамгийн муу утгатай гарсан нь салбарын голлох өөрчлөлт байлаа. Мөн худалдан авалтын тоо хэмжээ болон туслан гүйцэтгэгч ашиглалт тус бүр 12, борлуулалтын үйл ажиллагаа 3 улирал дараалан агшилтын мужид хэвээр гарлаа. Харин түүхий эд, материалын үнийн индекс эсрэгээрээ 12 улирал дараалан тэлэлтийн мужид гараад байна. Ирэх улирлын бизнесийн үйл ажиллагааны төлөвийн үзүүлэлт агшилтын мужид хэвээр хадгалагдсан хэдий ч өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар өслөө /Хүснэгт 2/.

**Дотоод худалдаа:** Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд 2023 оны IV улиралд бараа материалын нөөцийн үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарсан хэдий ч өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга 9.4, үйлдвэрлэл 6.4 нэгж хувиар тус бүр буурсан нь салбар ерөнхий үзүүлэлт буурч гарахад голлох нөлөөг үзүүлжээ. Тайлант улирлын ажил эрхлэлтийн индексийн утга өмнөх улирлаас 10.1 нэгж хувиар


**Зураг 6. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**



**Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	23.II	23.III	23.IV
Худалдан авалтын тоо хэмжээ	45.7↑	46.3↑	49.2↑
Түүхий эд, материалын үнэ	81.9↓	81.8	84.1↑
Орон сууцны зах зээлийн идэвхжил	46.3↑	59.1↑	21.9↓
Борлуулалтын үйл ажиллагаа	43.8↓	41.4↓	34.5↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	54.3↑	53.2↓	39.9↓
Туслан гүйцэтгэгч ашиглалт	49.7↑	46.0↓	46.8
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	56.8↓	44.4↓	45.3↑

**Зураг 7. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**



өсч, 53.9 гарсан нь түүхэн хамгийн өндөр үзүүлэлт болж байна /Зураг 7/.

Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд худалдан авсан барааны хэмжээний үзүүлэлт өмнөх улирлаас 16.7 нэгж хувиар буурсан хэдий ч тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Хүлээгдэж буй борлуулалтын үзүүлэлт өмнөх улирлаас 5.0 нэгж хувиар буурч, сүүлийн 6 улирал дараалан агшилтын мужид гарсан нь салбарын хүлээлт төдийлөн сайжрахгүй байгааг илтгэж байна /Хүснэгт 3/.


**Үйлчилгээ:** Салбарын ерөнхий бүх үзүүлэлтүүдийн хувьд тайлант улиралд тэлэлтийн мужид гарсан нь 2022 оны IV улирлаас хойшх анхны тохиолдол болж байна. Үйлдвэрлэл (бизнесийн идэвхжил) 7, шинэ захиалга сүүлийн 5 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр гарсан нь салбарын хувьд харьцангуй тогтвортой байгааг харууллаа. Ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 13.2 нэгж хувиар өсч, агшилтын мужаас тэлэлтийн мужид шилжсэн нь салбарын онцлох өөрчлөлт болж байна /Зураг 8/.

Тус салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд түүхий эд, материалын үнийн индексийн утга болон үйлчилгээний үнийн индексийн утга өндөр хэвээр хадгалагдсан бол дуусаагүй ажил, үйлчилгээ бага зэргийн өсөлттэй гарлаа. Мөн бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга өмнөх улирлаас 3.3 нэгж хувиар өсөж, сүүлийн 5 улирал дараалан тэлэх мужид гарлаа /Хүснэгт 4/.

**Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	2023.II	2023.III	2023.IV
Түүхий эд, материалын үнэ	67.0↓	88.1↑	85.0↓
Худалдан авсан барааны хэмжээ	62.5↓	81.1↑	64.4↓
Хүлээгдэж буй борлуулалт	45.2↑	43.5↓	38.6↓

**Зураг 8. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**



**Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	2023.II	2023.III	2023.IV
Түүхий эд, материалын үнэ	85.4↑	80.3↓	82.8↑
Үйлчилгээний үнэ	70.8↓	73.0↑	70.8↓
Дуусаагүй ажил үйлчилгээ	71.3↑	60.0↓	67.9↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	55.8↓	65.7↑	69.0↑


### 3. ААН-ийн ажиллагсдын тооны бүлгээр

**Ажиллагсдын тооны бүлэг:** Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (50 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 7 улирал, дунд ААН-үүдийн индексийн утга 5 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол жижиг ААН-үүдийн индексийн утга 12 улирал дараалан агших мужид гарлаа. Харин индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад дунд ААН-үүд 5.0, том ААН-үүд 3.1 нэгж хувиар тус бүр өсч, харгалзан 56.3%, 61.0%-тай байлаа. Харин жижиг ААН-үүдийн үзүүлэлт төдийлөн өөрчлөлтгүй буюу 46.5%-тай гарлаа /Зураг 9/.


**Жижиг:** ААН-үүдийн хувьд бүх үзүүлэлт агшилтын мужид гарсан хэдий ч ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 4.0 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин бараа материалын нөөцийн үзүүлэлт 6.1 нэгж хувиар буурч, агшилтын мужид шилжлээ. Бусад үзүүлэлтүүд харьцангуй өөрчлөлт багатай байлаа /Зураг 10/.

**Дунд:** ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлтээс бусад нь тэлэлтийн мужид гарсан бөгөөд өмнөх улиралтай харьцуулахад бүх үзүүлэлт өсөлттэй гарсан нь анхны тохиолдол болж байна. Тухайлбал, ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 14.2, үйлдвэрлэл 5.4 нэгж хувиар тус бүр нэмэгдэж, харгалзан 56.8, 61.5 гарсан нь бүх цаг үеийн хамгийн өндөр утга болж байна. Ийнхүү тус ангилалд хамаарах ААН-үүдийн ерөнхий үзүүлэлт 5.0 нэгж хувиар өслөө /Зураг 11/.


Зураг 9. Байгууллагын хэмжээгээр



Зураг 10. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр




Зураг 11. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр




**Том:** ААН-үүдийн хувьд ажил эрхлэлтийн үзүүлэлт сүүлийн 10, шинэ захиалга болон үйлдвэрлэлийн үзүүлэлт тус бүр 7, бараа материалын нөөц сүүлийн 4 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Улмаар сүүлийн 2 улиралд дараалан бүх үзүүлэлтүүд тэлэлтийн мужид гарлаа. Ажил эрхлэлт болон шинэ захиалгын үзүүлэлт өмнөх улирлаас харгалзан 14.8, 2.6 нэгж хувиар өссөн хэдий ч бараа материалын нөөц 4.5, үйлдвэрлэл 1.1 нэгж хувиар буурлаа /Зураг 12/.

**Зураг 12. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр**



#### 4. Олон улсын PMI индекс

**Зураг 13. Монгол болон худалдааны голлох түнш улсуудын PMI**



**Худалдааны голлох түнш улсуудын PMI<sup>1</sup>:** 2023 оны IV улиралд худалдааны голлох түнш улсуудын үзүүлэлт бага зэргийн өсөж, Евро бүсээс бусад орнуудад ерөнхий индекс тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Харин Евро бүсийн ерөнхий индексийн утга нэлээдгүй буурч тэлэлтийн мужаас агшилтын мужид шилжээд байна. БНХАУ-ын индексийн утга нь босго утгатай ойролцоо байгаа нь хэдий ч 2023 оны 8 дугаар сараас хойш тасралтгүй өсөж, улмаар бизнесийн идэвхжил нэмэгдэж байна. ОХУ-ын аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт 2023 оны IV улиралд үйлдвэрлэл болон шинэ захиалгын огцом өсөлтөөс үүдэлтэйгээр ажил эрхлэлтийг дэмжсэнээр ерөнхий үзүүлэлт хурдацтай сайжирч байна. Евро бүсийн шинэ захиалгын үзүүлэлт суларч, экспорт бага зэргийн буурч байгаа нь ерөнхий индексийн утгыг агшилтын мужид гарахад нөлөөлж байна Харин хүлээлтийн үзүүлэлт сүүлийн есөн сарын дээд түвшинд хүрчээ. АНУ-ын аж

<sup>1</sup> Голлох түнш улсуудын PMI индексийн тухайн улирлын сүүлийн сарын үзүүлэлтээр тооцсон болно.

үйлдвэрийн салбарын дотоод болон гадаад эрэлт нэмэгдэж, улмаар борлуулалт, ажил эрхлэлт нэмэгдсэн нь салбарын нөхцөл байдал хурдацтай сайжирч байгааг илтгэж байна. Дэлхийн PMI ерөнхий индекс 2023 оны 6-р сараас хойш хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт агшилтын мужид гарсан хэдий ч үйлчилгээний салбарын үзүүлэлт тэлэх мужид гарсан нь ерөнхий индекс тэлэлтийн мужид гарахад нөлөөллөө /Зураг 13/.

## 5. Хавсралт

### ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 500 орчим ААН-үүдийг **жижиг** (49 хүртэл ажилтантай), **дунд** (50-199 хүртэл ажилтантай), **том** (200-с дээш ажилтантай) гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Санал асуулгыг **2023 оны IV улиралд нийт 486** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 135, барилгын салбарын 114, дотоод худалдааны салбарын 101, үйлчилгээний салбарын 136** аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 323 (66%), дунд 121 (25%), том 42 (9%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр<sup>2</sup>**

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2023.IV*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (135)	Уул уурхай, олборлолт	1,131	7	2	4	13	3%
	Боловсруулах үйлдвэрлэл	6,696	69	27	7	103	21%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	293	9	4	1	14	3%
	Усан хангамж	249	2	2	1	5	1%
Барилга	Барилга	8,098	80	29	5	114	23%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	37,122	81	14	6	101	21%
Үйлчилгээ (136)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3,365	5	8	4	17	3%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажилл.	3,006	7	3	2	12	2%
	Мэдээлэл, холбоо	2,754	4	4	1	9	2%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,101	4	2	2	8	2%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,318	6	2		8	2%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	6,147	15	1	1	17	3%
	Боловсрол	3,824	5	6	2	13	3%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,612	6	8	4	18	4%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	1,040	2		1	3	1%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7,310	21	9	1	31	6%
<b>Нийт</b>		<b>87,066</b>	<b>323</b>	<b>121</b>	<b>42</b>	<b>486</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

<sup>2</sup> 2023 оны I улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо,



Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 25 (5%), 50-300 сая төгрөгийн 60 (12%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 73 (15%), 1-2.5 тэрбум төгрөгийн 80 (16%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 248 (51%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр**

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	7			7	1%
	50-300 сая₮ хүртэл	21			21	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	25	2		27	6%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	16	4		20	4%
	2.5 тэрбум₮ дээш	18	29	13	60	12%
Барилга	50 сая₮ хүртэл	2			2	0%
	50-300 сая₮ хүртэл	12	1		13	3%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	9	2		11	2%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	20	2		22	5%
	2.5 тэрбум₮ дээш	37	24	5	66	14%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	6			6	1%
	50-300 сая₮ хүртэл	11			11	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	13			13	3%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	11			11	2%
	2.5 тэрбум₮ дээш	40	14	6	60	12%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	10			10	2%
	50-300 сая₮ хүртэл	14	1		15	3%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	20	2		22	5%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	20	6	1	27	6%
	2.5 тэрбум₮ дээш	11	34	17	62	13%
Нийт	50 сая₮ хүртэл	25	-	-	25	5%
	50-300 сая₮ хүртэл	58	2		60	12%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	67	6	-	73	15%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	67	12	1	80	16%
	2.5 тэрбум₮ дээш	106	101	41	248	51%
Нийт		323	121	42	486	100%

### Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

**“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.**

**Аргачлал:** Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$\text{PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

$k1$  = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$  = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$  = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (49 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл<sup>3</sup> индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр<sup>4</sup> жигнэн тооцсон болно.

---

<sup>3</sup> Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

<sup>4</sup> Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, HIS Markit/.

## Аж үйлдвэр

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II	2023.III	2023.IV
<b>Аж үйлдвэр</b>	40.0%	40.9%	54.9%	52.1%	41.6%	56.2%	52.9%	59.8%	54.2%	59.0%	58.2%	62.1%
Шинэ захиалга	36.3%	40.5%	66.6%	62.4%	47.9%	60.1%	61.6%	66.0%	47.9%	62.6%	63.7%	64.0%
Үйлдвэрлэл	36.1%	40.8%	61.7%	61.0%	43.5%	56.8%	56.6%	63.6%	55.0%	65.9%	61.6%	68.1%
Ажил эрхлэлт	53.9%	45.1%	57.7%	58.5%	63.3%	60.6%	52.3%	71.8%	59.3%	53.6%	55.2%	69.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	37.2%	31.2%	23.3%	14.1%	10.6%	37.3%	35.8%	45.6%	54.2%	44.8%	47.3%	43.3%
Түүхий эд, материалын нөөц	37.3%	48.9%	45.1%	42.8%	21.4%	62.9%	44.5%	29.2%	61.0%	63.4%	56.0%	54.5%
<b>Жижиг</b>												
<b>Шинэ захиалга</b>	34.8%	38.6%	48.9%	44.9%	30.7%	32.8%	37.2%	38.6%	41.1%	52.1%	44.7%	43.7%
Үйлдвэрлэл	32.0%	38.6%	46.6%	35.2%	29.5%	34.5%	38.6%	44.7%	42.1%	49.3%	50.0%	44.1%
Ажил эрхлэлт	50.0%	43.2%	43.2%	48.9%	43.8%	40.8%	41.6%	45.2%	41.4%	39.7%	41.1%	42.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.4%	49.4%	42.6%	43.8%	25.0%	50.0%	42.6%	48.1%	52.6%	58.8%	50.6%	50.0%
Түүхий эд, материалын нөөц	38.8%	33.5%	43.8%	39.8%	34.1%	35.6%	29.6%	36.7%	42.0%	43.1%	51.3%	46.7%
Дуусаагүй үйлдвэрлэл	40.4%	43.2%	47.7%	46.0%	32.4%	50.0%	57.2%	48.7%	51.3%	54.4%	51.7%	48.1%
Бэлэн бүтээгдэхүүн	36.0%	40.3%	44.9%	43.2%	32.4%	37.9%	34.1%	42.6%	43.9%	50.0%	54.7%	46.7%
Бүтээгдэхүүний үнэ	65.2%	65.3%	64.2%	73.3%	66.5%	83.3%	70.4%	78.3%	72.2%	69.1%	68.8%	64.9%
Худалдан авалтын тоо хэмжээ	44.9%	54.0%	61.4%	46.0%	51.1%	34.5%	40.4%	36.1%	39.9%	46.7%	46.7%	49.4%
Түүхий эд, материалын үнэ	86.5%	88.6%	85.2%	85.2%	84.1%	92.5%	89.2%	90.7%	85.8%	84.5%	79.6%	80.4%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.6%	57.4%	61.4%	46.0%	58.5%	55.1%	36.5%	63.8%	57.1%	51.5%	51.7%	50.6%
<b>Дунд</b>												
<b>Шинэ захиалга</b>	37.0%	48.0%	44.0%	50.0%	30.0%	50.0%	50.0%	52.0%	51.0%	53.4%	58.6%	63.6%
Үйлдвэрлэл	37.0%	52.0%	38.0%	40.0%	32.0%	52.0%	48.1%	63.0%	53.9%	62.1%	56.7%	71.2%
Ажил эрхлэлт	50.0%	48.0%	46.0%	50.0%	52.0%	50.0%	42.3%	48.1%	52.9%	43.1%	41.1%	60.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.5%	26.0%	42.0%	32.0%	12.0%	38.0%	38.5%	48.0%	43.9%	43.1%	46.6%	46.9%
Түүхий эд, материалын нөөц	47.8%	52.0%	48.0%	20.0%	32.0%	42.0%	44.0%	35.2%	50.0%	59.1%	53.7%	54.5%
Дуусаагүй үйлдвэрлэл	41.3%	56.0%	58.0%	48.0%	48.0%	60.0%	58.3%	55.8%	46.7%	62.1%	64.3%	63.6%
Бэлэн бүтээгдэхүүн	50.0%	56.0%	60.0%	48.0%	48.0%	44.0%	47.9%	46.3%	55.1%	52.3%	51.9%	51.6%
Бүтээгдэхүүний үнэ	58.7%	66.0%	68.0%	64.0%	76.0%	88.0%	78.8%	73.1%	79.4%	71.7%	63.3%	69.7%
Худалдан авалтын тоо хэмжээ	56.5%	60.0%	50.0%	56.0%	50.0%	56.0%	47.7%	51.9%	50.0%	47.8%	64.8%	56.1%
Түүхий эд, материалын үнэ	82.6%	86.0%	90.0%	84.0%	88.0%	92.0%	88.0%	94.2%	93.0%	86.7%	77.6%	87.1%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	56.5%	54.0%	60.0%	60.0%	52.0%	45.5%	36.4%	69.6%	63.0%	52.2%	63.8%	51.5%
<b>Том</b>												
<b>Шинэ захиалга</b>	36.4%	40.0%	70.0%	65.0%	50.0%	63.6%	65.0%	70.0%	47.9%	64.7%	65.8%	65.4%
Үйлдвэрлэл	36.4%	40.0%	65.0%	65.0%	45.0%	59.1%	59.1%	65.0%	56.0%	67.6%	63.2%	69.2%
Ажил эрхлэлт	54.5%	45.0%	60.0%	60.0%	65.0%	63.6%	54.5%	77.3%	61.5%	56.3%	58.3%	73.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.4%	30.0%	20.0%	10.0%	10.0%	36.4%	35.0%	45.0%	56.0%	44.1%	47.2%	42.3%
Түүхий эд, материалын нөөц	36.4%	50.0%	45.0%	45.0%	20.0%	68.2%	45.5%	27.8%	64.0%	65.4%	56.7%	55.0%
Дуусаагүй үйлдвэрлэл	36.4%	40.0%	50.0%	55.0%	40.0%	59.1%	65.0%	50.0%	52.2%	64.7%	61.1%	61.5%
Бэлэн бүтээгдэхүүн	54.5%	55.0%	35.0%	60.0%	40.0%	68.2%	54.5%	33.3%	65.4%	61.5%	66.7%	55.0%
Бүтээгдэхүүний үнэ	72.7%	55.0%	80.0%	80.0%	75.0%	86.4%	85.0%	68.2%	80.0%	61.8%	69.4%	69.2%
Худалдан авалтын тоо хэмжээ	27.3%	50.0%	45.0%	65.0%	60.0%	77.3%	70.0%	60.0%	53.8%	53.6%	73.3%	60.0%
Түүхий эд, материалын үнэ	86.4%	75.0%	95.0%	100.0%	100.0%	81.8%	95.0%	88.9%	86.5%	82.4%	89.5%	80.8%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.6%	60.0%	65.0%	85.0%	65.0%	83.3%	38.9%	59.1%	53.8%	53.1%	50.0%	88.5%

## Барилга

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II	2023.III	2023.IV
<b>Барилга</b>	29.9%	38.7%	36.5%	31.4%	38.0%	36.3%	36.4%	29.7%	44.5%	53.7%	42.1%	37.3%
Шинэ захиалга	25.7%	43.3%	44.7%	32.9%	37.0%	30.7%	34.1%	21.0%	35.4%	54.4%	41.1%	21.9%
Үйлдвэрлэл	23.3%	39.0%	39.0%	33.6%	32.8%	35.6%	35.7%	26.8%	40.8%	51.2%	44.2%	38.1%
Ажил эрхлэлт	43.2%	47.1%	40.9%	35.8%	47.1%	37.8%	38.8%	30.4%	59.3%	61.2%	36.8%	47.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	34.4%	23.8%	19.2%	28.7%	43.7%	58.4%	49.4%	58.7%	48.4%	51.7%	42.0%	53.5%
Түүхий эд, материалын нөөц	25.8%	29.3%	23.2%	16.2%	27.0%	18.6%	21.0%	17.8%	45.0%	45.4%	51.2%	37.5%
<b>Жижиг</b>												
<b>Шинэ захиалга</b>	25.6%	35.0%	42.5%	35.0%	33.3%	27.8%	28.6%	25.6%	39.3%	40.9%	34.2%	35.9%
Үйлдвэрлэл	22.2%	31.3%	42.5%	36.3%	29.8%	30.0%	31.0%	26.1%	47.5%	43.4%	34.4%	44.9%
Ажил эрхлэлт	43.3%	47.5%	45.0%	41.3%	44.0%	36.7%	34.3%	31.6%	41.1%	34.8%	25.0%	46.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	41.1%	37.5%	26.3%	28.8%	46.4%	53.3%	59.6%	62.0%	54.5%	52.8%	48.0%	56.8%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	27.5%	32.5%	25.0%	20.2%	12.2%	22.5%	21.9%	38.6%	35.4%	50.7%	39.1%
Худалдан авалтын тоо хэмжээ	22.2%	40.0%	45.0%	31.3%	35.7%	42.2%	37.8%	32.6%	42.2%	38.6%	39.2%	44.9%
Түүхий эд, материалын үнэ	92.2%	93.8%	91.3%	87.5%	82.1%	90.0%	92.9%	93.8%	89.8%	88.1%	89.4%	85.6%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	24.3%	45.5%	58.3%	48.6%	47.6%	43.3%	36.4%	21.1%	33.3%	43.1%	31.5%	39.0%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.4%	40.0%	42.5%	40.0%	33.3%	37.8%	34.8%	27.3%	67.8%	37.7%	35.2%	41.1%
Барилга, усралтын үйл ажиллагаа	16.7%	45.0%	41.3%	36.3%	34.5%	38.9%	38.5%	25.6%	41.2%	40.8%	47.4%	39.9%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.3%	48.8%	40.0%	37.5%	45.2%	41.1%	47.7%	44.3%	47.1%	46.9%	46.0%	50.9%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	77.8%	60.0%	26.3%	45.0%	75.0%	43.5%	36.9%	57.3%	53.3%	56.4%	59.9%	53.8%
<b>Дунд</b>												
<b>Шинэ захиалга</b>	30.5%	50.0%	44.4%	22.2%	34.4%	31.0%	27.6%	22.9%	42.9%	56.3%	29.2%	27.8%
Үйлдвэрлэл	26.8%	38.9%	34.4%	25.6%	32.2%	32.1%	36.9%	27.9%	50.0%	44.0%	41.7%	48.2%
Ажил эрхлэлт	47.6%	46.7%	38.9%	37.8%	43.3%	35.7%	33.3%	24.3%	62.0%	48.1%	34.0%	41.4%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	28.0%	22.2%	17.8%	34.4%	40.0%	58.3%	70.3%	62.5%	54.0%	54.0%	54.3%	57.7%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	28.9%	22.2%	11.1%	23.3%	9.5%	17.1%	16.2%	56.0%	45.8%	54.3%	30.8%
Худалдан авалтын тоо хэмжээ	26.8%	46.7%	38.9%	17.8%	41.1%	42.9%	30.3%	27.9%	52.0%	43.8%	45.7%	51.9%
Түүхий эд, материалын үнэ	91.5%	90.0%	94.4%	91.1%	85.6%	88.1%	93.8%	94.6%	92.0%	90.4%	88.6%	91.1%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	38.9%	52.6%	55.4%	37.2%	51.1%	44.0%	33.9%	34.6%	35.3%	41.7%	35.7%	30.0%
Борлуулалтын үйл ажиллагаа	29.3%	40.0%	42.2%	26.7%	34.4%	26.2%	32.1%	26.6%	73.1%	36.7%	44.4%	37.5%
Барилга, усралтын үйл ажиллагаа	28.0%	51.1%	46.7%	21.1%	32.2%	34.5%	26.9%	25.8%	58.8%	41.7%	39.6%	39.7%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.9%	53.3%	46.7%	25.6%	47.8%	45.2%	37.1%	27.6%	50.0%	30.8%	37.5%	56.8%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	72.0%	62.2%	30.0%	41.1%	68.9%	42.4%	27.6%	63.0%	53.8%	54.0%	43.5%	48.1%
<b>Том</b>												
<b>Шинэ захиалга</b>	16.1%	43.1%	45.8%	38.9%	41.2%	32.4%	41.4%	17.9%	30.0%	60.0%	50.0%	12.5%
Үйлдвэрлэл	17.9%	43.1%	40.3%	37.5%	35.3%	41.2%	37.9%	26.7%	33.3%	58.3%	50.0%	30.0%
Ажил эрхлэлт	33.9%	47.2%	40.3%	31.9%	51.5%	39.7%	44.8%	32.8%	66.7%	80.0%	43.8%	50.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	35.7%	18.1%	16.7%	25.0%	44.1%	61.8%	30.8%	55.4%	42.9%	50.0%	33.3%	50.0%
Түүхий эд, материалын нөөц	26.8%	30.6%	19.4%	15.3%	33.8%	27.9%	22.4%	16.7%	42.9%	50.0%	50.0%	40.0%
Худалдан авалтын тоо хэмжээ	21.4%	51.4%	38.9%	22.2%	44.1%	42.6%	36.5%	25.9%	33.3%	50.0%	50.0%	50.0%
Түүхий эд, материалын үнэ	78.6%	100.0%	98.6%	81.9%	79.4%	79.4%	96.6%	89.3%	100.0%	75.0%	75.0%	80.0%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	28.0%	53.6%	55.4%	37.1%	41.2%	42.6%	47.7%	16.7%	50.0%	50.0%	83.3%	10.0%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.3%	40.3%	47.2%	36.1%	42.6%	39.7%	53.8%	23.2%	78.6%	50.0%	42.9%	30.0%
Барилга, усралтын үйл ажиллагаа	25.0%	44.4%	54.2%	34.7%	41.2%	36.8%	39.7%	20.7%	25.0%	66.7%	62.5%	40.0%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	37.5%	44.4%	48.6%	33.3%	48.5%	48.5%	53.8%	33.3%	50.0%	60.0%	50.0%	40.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	69.6%	66.7%	36.1%	50.0%	58.8%	53.1%	41.1%	54.2%	62.5%	58.3%	37.5%	40.0%

## Дотоод худалдаа

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II	2023.III	2023.IV
<b>Дотоод худалдаа</b>	33.1%	36.4%	43.3%	45.7%	33.5%	46.4%	37.7%	47.0%	56.0%	52.9%	54.8%	53.3%
Шинэ захиалга	22.7%	31.4%	42.5%	46.5%	39.1%	45.4%	34.8%	44.8%	54.1%	54.3%	60.8%	51.5%
Үйлдвэрлэл	29.1%	36.2%	47.3%	52.6%	23.7%	50.8%	37.1%	51.9%	68.1%	72.5%	63.9%	57.5%
Ажил эрхлэлт	47.8%	44.7%	49.6%	51.6%	47.8%	49.2%	43.3%	44.7%	53.7%	41.3%	43.7%	53.9%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.1%	35.8%	36.4%	29.7%	19.7%	43.6%	35.2%	43.6%	42.4%	32.1%	46.5%	56.3%
Түүхий эд, материалын нөөц	31.1%	36.4%	33.7%	37.9%	33.1%	36.4%	40.7%	51.1%	56.4%	53.8%	48.7%	42.4%
<b>Жижиг</b>												
Шинэ захиалга	21.1%	32.6%	40.0%	34.2%	38.9%	42.6%	32.6%	37.6%	46.5%	45.8%	48.1%	48.0%
Үйлдвэрлэл	23.7%	33.7%	45.8%	42.1%	26.8%	44.2%	32.8%	37.5%	50.7%	54.3%	57.9%	53.2%
Ажил эрхлэлт	43.2%	41.6%	47.4%	47.4%	45.8%	44.2%	43.0%	38.8%	40.8%	39.6%	43.2%	46.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.8%	40.5%	32.1%	32.6%	21.1%	42.1%	41.8%	45.6%	46.9%	45.7%	46.9%	52.1%
Түүхий эд, материалын нөөц	34.2%	32.6%	30.5%	28.9%	33.2%	37.4%	44.4%	50.0%	44.8%	40.7%	47.0%	37.9%
Худалдан авсан барааны дундаж үнэ	70.5%	71.1%	79.5%	82.1%	82.1%	79.5%	83.5%	90.4%	81.9%	79.2%	76.8%	81.9%
Худалдан авсан барааны хэмжээ	55.3%	54.7%	63.7%	58.9%	69.5%	75.3%	80.8%	82.1%	88.4%	54.3%	74.6%	66.9%
Хүлээгдэж буй борлуулалт	11.1%	19.5%	17.9%	24.2%	20.0%	61.1%	41.5%	50.0%	26.3%	33.0%	36.9%	32.7%
<b>Дунд</b>												
Шинэ захиалга	21.9%	31.3%	43.8%	50.0%	37.5%	40.6%	38.2%	39.5%	54.5%	53.8%	61.5%	42.3%
Үйлдвэрлэл	31.3%	34.4%	59.4%	53.1%	37.5%	56.3%	41.7%	55.3%	69.2%	59.1%	67.9%	42.3%
Ажил эрхлэлт	43.8%	40.6%	56.3%	56.3%	59.4%	46.9%	44.7%	47.4%	65.4%	42.3%	46.7%	57.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	31.3%	21.9%	12.5%	18.8%	15.6%	43.8%	31.6%	26.3%	50.0%	31.8%	38.5%	38.5%
Түүхий эд, материалын нөөц	37.5%	25.0%	40.6%	62.5%	40.6%	25.0%	44.7%	55.6%	62.5%	62.5%	50.0%	62.5%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	71.9%	90.6%	96.9%	90.6%	84.4%	84.2%	94.7%	72.7%	73.1%	90.0%	82.1%
Худалдан авсан барааны хэмжээ	53.1%	62.5%	78.1%	68.8%	68.8%	87.5%	85.3%	89.5%	90.9%	77.3%	86.4%	87.5%
Хүлээгдэж буй борлуулалт	18.8%	12.5%	18.8%	31.3%	15.6%	66.7%	39.5%	52.8%	34.6%	34.6%	33.3%	29.2%
<b>Том</b>												
Шинэ захиалга	25.0%	30.0%	45.0%	60.0%	40.0%	50.0%	35.7%	55.6%	62.5%	64.3%	75.0%	60.0%
Үйлдвэрлэл	35.0%	40.0%	45.0%	65.0%	15.0%	55.0%	40.0%	66.7%	87.5%	100.0%	68.8%	70.0%
Ажил эрхлэлт	55.0%	50.0%	50.0%	55.0%	45.0%	55.0%	42.9%	50.0%	62.5%	42.9%	42.9%	60.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.0%	35.0%	50.0%	30.0%	20.0%	45.0%	28.6%	50.0%	33.3%	16.7%	50.0%	70.0%
Түүхий эд, материалын нөөц	25.0%	45.0%	35.0%	40.0%	30.0%	40.0%	33.3%	50.0%	66.7%	64.3%	50.0%	37.5%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	85.0%	65.0%	85.0%	75.0%	75.0%	92.9%	77.8%	62.5%	50.0%	100.0%	90.0%
Худалдан авсан барааны хэмжээ	55.0%	65.0%	65.0%	70.0%	60.0%	80.0%	83.3%	66.7%	75.0%	64.3%	85.7%	50.0%
Хүлээгдэж буй борлуулалт	20.0%	30.0%	30.0%	45.0%	20.0%	42.9%	64.3%	41.7%	50.0%	64.3%	56.3%	50.0%

## Үйлчилгээ

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I	2023.II	2023.III	2023.IV
<b>Үйлчилгээ</b>	31.0%	40.4%	41.0%	42.2%	44.1%	55.3%	51.2%	51.3%	54.8%	53.5%	53.9%	59.8%
Шинэ захиалга	30.3%	38.9%	42.9%	41.3%	43.5%	56.0%	47.5%	51.6%	52.2%	54.0%	52.8%	65.1%
Борлуулалтын орлого	28.4%	42.2%	45.6%	48.5%	49.0%	53.4%	55.7%	50.4%	66.2%	59.1%	63.9%	59.9%
Ажил эрхлэлт	39.1%	51.1%	47.7%	54.0%	53.7%	63.0%	53.9%	52.1%	58.9%	51.7%	43.8%	56.9%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.2%	26.5%	21.5%	18.6%	25.1%	47.0%	47.4%	51.3%	36.5%	46.4%	53.3%	53.5%
<b>Жижиг</b>												
Шинэ захиалга	18.2%	33.3%	45.8%	45.2%	39.3%	45.2%	40.4%	38.5%	46.2%	49.6%	44.9%	45.9%
Борлуулалтын орлого	17.5%	35.7%	47.0%	48.8%	41.7%	48.2%	44.6%	43.4%	50.0%	53.3%	50.7%	54.0%
Ажил эрхлэлт	43.5%	46.4%	39.3%	48.2%	50.6%	48.8%	48.8%	42.2%	40.1%	42.5%	42.9%	48.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	39.6%	29.8%	29.8%	20.8%	19.6%	45.8%	42.4%	52.1%	51.4%	49.2%	49.1%	46.4%
Түүхий эд, материалын үнэ	76.6%	83.9%	88.1%	92.9%	89.3%	83.9%	89.0%	92.5%	85.0%	87.0%	81.5%	76.8%
Үйлчилгээний үнэ	43.5%	50.0%	53.0%	57.7%	56.5%	72.0%	67.5%	70.6%	68.5%	67.9%	64.2%	63.5%
Дуусаагүй ажил үйлчилгээ	53.2%	62.5%	60.7%	61.9%	57.1%	56.0%	68.8%	61.0%	55.1%	71.8%	44.8%	68.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	46.8%	53.0%	43.5%	52.4%	65.5%	53.6%	36.0%	52.5%	59.9%	51.7%	52.8%	46.2%
<b>Дунд</b>												
Шинэ захиалга	23.9%	43.1%	32.8%	32.8%	37.9%	56.7%	40.4%	53.3%	45.3%	60.3%	54.8%	57.5%
Борлуулалтын орлого	23.9%	43.1%	37.9%	36.2%	39.7%	60.0%	51.7%	54.8%	51.4%	60.3%	53.6%	58.3%
Ажил эрхлэлт	39.1%	50.0%	37.9%	48.3%	43.1%	55.0%	51.7%	54.8%	51.4%	52.6%	44.2%	54.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.1%	29.3%	27.6%	25.9%	19.0%	45.0%	38.9%	55.3%	59.4%	50.0%	42.1%	48.8%
Түүхий эд, материалын үнэ	76.1%	63.8%	79.3%	93.1%	75.9%	73.3%	81.0%	84.0%	92.2%	85.7%	85.7%	83.8%
Үйлчилгээний үнэ	52.2%	53.4%	50.0%	55.2%	50.0%	63.3%	53.6%	65.0%	66.7%	70.0%	70.2%	59.8%
Дуусаагүй ажил үйлчилгээ	60.9%	56.9%	56.9%	58.6%	62.1%	63.3%	64.3%	50.0%	53.7%	83.3%	48.7%	63.2%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	39.1%	53.4%	41.4%	50.0%	63.8%	42.0%	43.1%	62.0%	65.3%	59.7%	61.5%	65.0%
<b>Том</b>												
Шинэ захиалга	35.3%	38.6%	45.5%	43.2%	45.5%	57.1%	50.0%	52.9%	55.0%	52.8%	53.3%	70.0%
Борлуулалтын орлого	32.4%	43.2%	47.7%	52.3%	52.3%	52.4%	57.9%	50.0%	72.7%	59.5%	68.8%	61.1%
Ажил эрхлэлт	38.2%	52.3%	52.3%	56.8%	56.8%	66.7%	55.0%	52.6%	63.6%	52.6%	43.8%	58.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	23.5%	25.0%	18.2%	15.9%	27.3%	47.6%	50.0%	50.0%	27.8%	45.0%	57.1%	55.9%
Түүхий эд, материалын үнэ	85.3%	81.8%	90.9%	86.4%	88.6%	76.2%	89.5%	83.3%	80.0%	85.0%	78.6%	83.3%
Үйлчилгээний үнэ	38.2%	47.7%	59.1%	59.1%	56.8%	73.8%	66.7%	61.1%	72.7%	71.4%	75.0%	75.0%
Дуусаагүй ажил үйлчилгээ	47.1%	54.5%	56.8%	56.8%	68.2%	50.0%	50.0%	57.1%	44.4%	67.6%	65.4%	69.2%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	61.8%	70.5%	56.8%	54.5%	54.5%	53.1%	50.0%	55.6%	77.3%	55.3%	68.8%	73.3%